

**ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН
ХАРИЛЦАА**



МОНГОЛ ДАХЬ УМАРД СОЛОНГОСЫН АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВ

Б.Батсайхан*

***Abstracts:** The economic difficulties facing the North Korea, and in this regard, one of the methods of obtaining the currency by the North Korean authorities began sending labor forces abroad. Since mid-2000, the labor forces of North Korea has been sent to Russia, China, Southeast Asia, Middle East, and Eastern Europe, as well as Mongolia, etc. early the kept good relations country. The main documents that related to labor forces of North Korea to Mongolia is the agreement signed between the two countries in 2007 by “mutual exchange of labor forces”, and from 2010, the year began to take the of the North Korean labor forces to Mongolia. Basically North Korean labor forces in Mongolia work in construction, in agriculture, in the textile factory. In article the branch, number, qualification, conditions of North Korean workers in Mongolia is considered in brief, and it is given the general representations.*

***Key words:** North Korean labors fors in Mongolia, their branch, number, qualification, conditions*

* * *

БНАСАУ гадаадад ажиллах хүч гаргах болсон шалтгаан, нөхцөл

БНАСАУ (УС) бол социалист, төлөвлөгөөт эдийн засгийн харилцаатай улс ба социалист хамтын нөхөрлөл /ЭЗХТЗ/-ийн гишүүн орон байв. Тэр дундаа ЗХУ-тай эдийн засгийн нягт харилцаатай байж, 1990 оны байдлаар БНАСАУ-ын гадаад худалдааны нийт эргэлтийн 53.3 хувь буюу 2.2 тэрбум долларыг ЗХУ, 20 гаруй хувийг БНХАУ, бусад хувийг социалист орнууд эзэлж байв. ЗХУ-ын тусламжтай баригдсан 70 гаруй томоохон аж үйлдвэрийн объектод эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 70 хувь, химийн бордооны 50 хувь, хар төмөрлөгийн 40 хувийг үйлдвэрлэж байв.¹⁵⁹ Социалист систем нуран унаснаар БНАСАУ-ын эдийн засаг маш хүчтэй цохилтонд орсон. БНАСАУ-ын дотоодын нийт бүтээгдэхүүн (GDP) жил ирэх тусам улам бүр эрчимтэй байнга унаж, тухайлбал: 1990 онд 3.7 хувь, 1991 онд 5.1 хувь, 1992 онд 7.7 хувь, 1993 онд 4.2 хувь, 1994 онд 1.8 хувь, 1995 онд 4.6 хувиар буурчээ.¹⁶⁰ Эдийн засгийнх нь гол хөдөлгөгч хүч болох Зөвлөлт маягийн хүнд үйлдвэрлэл нь бараг зогсч, 1997 оны байдлаар аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн хэмжээ 1990 оны түвшинтэй харьцуулахад дөнгөж 46 хувийг эзлэх болжээ. Хүн амынх нь хэрэгцээг олон жил хангаж байсан картын систем ч 1996 оноос бараг бүрмөсөн зогссон байна. Үүнтэй зэрэгцээд 1995 онд УС-т их хэмжээний үер болж ургац алдсаны улмаас хүн ам нь өлсгөлөнд нэрвэгдэн

* МУИС-ийн ОУХНУС-ийн ОУХ-ны тэнхимийн докторант

¹⁵⁹ Л.В. Захарова. Экономические отношения России и КНДР в XXI в. // Азия и Африка сегодня. 2015, №5. - С. 15-21.

¹⁶⁰ Gross Domestic Product of North Korea in 2007. Seoul, Bank of Korea. 18 June 2008. P.1.

2001 оны 5 сарын 15-ны өдрийн UNICEF-ийн тайланд 1995-1998 оны хооронд БНАСАУ-д 220.000 хүн өлсгөлөнгийн улмаас амь үрэгдэж, дундаж наслалт 6.4 жилээр багассан гэж илтгэжээ.¹⁶¹ Гэхдээ бодит байдал дээр энэ тоо хэд дахин давна гэж үздэг ч нэлээд бодит судалгаагаар 600-900 мянган хүний амь үрэгдсэн гэсэн дүгнэлтийг судлаачид гаргасан байдаг.¹⁶² УС-ын энэхүү хүнд нөхцөл байдлын үед олон улсын хамтын нийгэмлэгийн тусламж чухал үүрэг гүйцэтгэсэн байна. БНАСАУ-ын эрх баригчдын хүсэлтийн дагуу олон улсын хамтын нийгэмлэгээс үзүүлсэн тусламжийн хэмжээ, тухайлбал: 1996 онд 900 мян.т., 1997 онд 1.2 сая т., 1998 онд 1.3 сая т. хүнсний тусламж үзүүлсний ихэнхийг нь АНУ, БНХАУ, Өмнөд Солонгос, Япон зэрэг улс олгосноос, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагаас (The US Agency for International Development) гаргасан тайлангаас авч үзвэл 1994-2002 оны хооронд АНУ БНАСАУ-д 620 сая ам.долларын тусламж олгосон байна.

Эдийн засгийн хямрал УС-ын олон арван үйлдвэрийн газруудыг сул зогсоход хүргэж, 1990 онд 40 хувийг эзэлж байсан үйлдвэрийн хүчин чадлын ашиглалтын коэффициент 1996 онд 25 хувьд хүрч буурсан ба өнөө ч энэ хувь буурсаар 20 хувьд хүрчээ.¹⁶³ Энэ нь олон тооны ажилчид үйлдвэрийн орон тоон дээр бүртгэлтэй боловч үнэн хэрэгтээ цалин хөлсгүй, ажилгүйчүүд болон хувирчээ.

Мөн эдийн засгийн гол тулгуур болох тус улсын гадаад худалдаа нэн хүнд байдалд оров. 1990 онд ЗХУ ба БНАСАУ-ын гадаад худалдааны эргэлтийн хэмжээ 2.5 млрд долларт хүрч байсан бол 1991 онд 365 мянган ам.доллар болж огцом буурчээ. 1993 оны байдлаар УС-ын импортод ОХУ-ын эзлэх хувь хэмжээ 80-аад оныхтой харьцуулахад зөвхөн 10 хувийг эзлэх болов.¹⁶⁴ Өмнөх социалист системийн орнуудын гадаад худалдааны онцлог нь цөөн хэдэн орны хооронд ингэхдээ бэлэн мөнгөөр төлбөр тооцоо хийх явдал нэн ховор, ө.х. өөрсдийн орондоо үйлдвэрлэдэггүй хэрэгцээт барааг импортоор худалдан авахын оронд өөр барааг экспортлох буюу сольж авах-бартерын худалдааг урьтал болгож, мөн энэ бүх харилцааг дан ганц улс зохицуулж, ЗХУ-ын рубль төлбөр тооцооны гол хэрэгсэл болж байсан бол 90-ээд оноос гадаад худалдаа чөлөөтэй болж, гадаад худалдааны төлбөр тооцооны гол хэрэгсэл нь валют буюу ам.доллар-аар солигдож, гадаад худалдааны оролцогч нь зөвхөн улс биш аж ахуйн нэгж, хувь хүн болж энэ харилцаа давамгайлах болсон. Харин УС-ын хувьд гадаад худалдаа нь чөлөөлөгдөөгүй, оролцогч нь улс хэвээр үлдсэний улмаас энэ харилцаа хөгжөөгүй тул тус улс валютын хомсдолд орсон юм. УС-ын гадаад худалдааны нийт эргэлт 1990 онд 4.170 тэрбум долларт хүрч байсан бол 1998 онд 1.442 тэрбум болж огцом буурчээ.¹⁶⁵ 1999 оноос л гадаад худалдаа нь бага зэрэг сэргэж 2004 онд 2.857 тэрбум долларт хүрч, сүүлийн үед өссөн үзүүлэлттэй байгаа ч гадаад худалдаа нь алдагдалтай, цөөн хэдэн орноор хязгаарлагдсан хэвээр байна.

¹⁶¹ “연합뉴스”, 제 1264 호. 2001.5.24

¹⁶² А.Ланьков. Северная Корея после 2002 г. Попытка контр-реформ. Stephen Huggard and Marcus Noland. Famine in North Korea. P. 27.

¹⁶³ 박형중, 『북한의 경제관리체계: 기구와 운영, 개혁과 변화』 (서울: 하남, 2002), p.29.

¹⁶⁴ Stephen Huggard and Marcus Noland. Famine in North Korea: Markets, Aid and Reform. New York, Columbia University Press. 2007. p. 27./

¹⁶⁵ /KOTRA 해외무역관 보고/

Эдийн засгийн энэ бүх хүндрэлийг даван туулахын тулд БНАСАУ гадаад дотоод нэлээдгүй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн юм. Юун түүрүүнд гадаад харилцаагаа өргөжүүлэх алхамууд, тухайлбал, хоёр Солонгосын хоорондын яриа хэлэлцээрийг үргэлжлүүлэх, эдийн засгийн хөгжилтэй Өмнөд Солонгостой харилцаа тогтоох хүчин чармайлт гаргаж эхэлжээ. 1990 оноос хоёр Солонгосын олон нийтийн байгууллага төдийгүй засгийн газар хоорондын төлөөлөгчдийн уулзалт хэлэлцээрүүд явагдсаны үр дүнд 1991 оны 12 дугаар сарын 13-нд Сөүлд “Найрамдал, үл довтлох, Умард Өмнөдийн хоорондын хамтын ажиллагаа, солилцооны тухай хэлэлцээр”-т гарын үсэг зуржээ. Үүний хажуугаар тус улс барууны улс орнууд болон АНУ-тай эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэхийг оролдож байв. 1993 оноос Хойд Хамгён мужид Нажин-Сонбоны эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулж, 1994 онд АНУ-тай цөмийн эрчим хүчний салбарт хамтран ажиллах яриа хэлэлцээрүүдийг байгуулж байв.

Дотооддоо эдийн засгаа сэргээх гэсэн оролдлогууд дунд 2002 онд явуулсан БНАСАУ-ын ЗГ-ын эдийн засгийн “шинэчлэл”¹⁶⁶ буюу зах зээлийн эдийн засгийн элементүүдийг нэвтрүүлэх бодлого нь нэлээд амжилтанд хүрчээ. Энэ “шинэчлэлээр” картын системийг үндсэнд нь халж, үнийг чөлөөлснөөр 80 чонтой (1 чон-1/100вон) тэнцэж байсан 1 кг будааны үнэ 44 вон болсны дээр ажилчдын цалин ч бага хэмжээгээр нэмэгдсэн байна. /Лим Кёнхыны тооцоолсноор жижиглэнгийн үнийг дунджаар 25 дахин нэмэгдүүлсэн бол цалин хөлсийг 18 дахин нэмэгдүүлжээ/.¹⁶⁷ Мөн БНАСАУ гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилготой эдийн засгийн чөлөөт бүсийн тухай хэд хэдэн тусгай хууль гаргав. 2002 оны 9 дүгээр сарын 12-нд БНАСАУ-ын ХН-ын Байнгын Хорооноос БНХАУ-тай хиллэдэг Син Ы Жу-г засаг захиргааны онцгой бүс болгох тухай хууль гаргаж, Хойд Пёнъян мужийн захиргаанаас гаргаж, 50 жилийн хугацаатай бие даасан засаг захиргааны нэгж болгож, энэ бүсийг олон улсын санхүү, худалдаа, үйлдвэр, шинэ технологи, аялал жуулчлалын төв болгохоор төлөвлөж, төсөлд оролцогчдын хөрөнгө оруулалтыг улсаас хамгаалахаар тусгажээ. Гэхдээ энэ төсөл төд удалгүй сарын дараа тусгай бүс нутгийн захирагч Ян Бин-ийг хээл хахуулийн хэргээр баривчилснаар зогссон ажээ. 2002 оны 10 дугаар сарын 23-нд хоёр Солонгосыг тусгаарлах бүсийн ойролцоо зүүн өмнөд бүс нутагт “Кымганы жуулчны бүсийн тухай хууль” гаргаж, Өмнөд Солонгосын бизнес эрхлэгчдэд хөнгөлөлттэй нөхцөлөөр бизнес хийх, мөн Өмнөд Солонгосын жуулчдыг хүлээн авахаар болсны зэрэгцээ “Кэсоны аж үйлдвэрийн бүс”-ийн тухай хууль гаргаж, Кэсон-д аж үйлдвэрийн цогцолбор байгуулж, уг төсөл амжилттай хэрэгжсэн. 2002 оны 3 дугаар сарын 28-нд БНАСАУ-д “Улсын газрыг төлөвлөх тухай хууль” /кугту кэхуй поб/ гаргаж, 2003 оны намар БНАСАУ-д гар утасны сүлжээний системийг байгуулж, нэгдсэн зах /жунхаб шижан/-ыг ч байгуулжээ.

¹⁶⁶ Дээр дурьдсан 2002 оны үйл явлуудыг гадаадын хэвлэл мэдээллээр эдийн засгийн шинэчлэл гэж бичдэг ч УС-ын хэвлэл мэдээллээр “эдийн засгийн удирдлагыг сайжруулах арга хэмжээ буюу 7 сарын 1-ний арга хэмжээ” гэж нэрийдэж иржээ.

¹⁶⁷ (А.Ланьков. Северная Корея после 2002 г. Попытка контр-реформ. Лим Гёнхын. “Пукхансик кёнче кэхёг-е тэхан пхёнга-ва чонман: 7.1 кёнче кванли кэсон чончхи-рыль чунсим-ыро” [Оценка и перспектива реформ в северокорейском стиле; мерами по улучшению управления экономикой 1-го июля] // Хангук чончхи-ый ёнгү 16, №.1. 2007: Р. 290, 295-391./

2004 оны үед БНАСАУ Хятадтай хиллэдэг хилийн хяналтаа сулруулснаар УС-ын иргэд Хятад руу хууль бусаар гарч ажиллах, наймаа хийх явдал ихэсчээ. УС-ын олон тооны иргэд нутгаасаа дүрвэсний ихэнхи нь Хятадын Манжуур луу гарчээ. 1998-1999 онд Хятадад гарсан дүрвэгчдийн тоо 200-250 мянгад хүрч байв. Мөн 2000 оны дунд үеээс БНАСАУ-ын нам, төр, цэргийн гадаад харилцааны байгууллагууд гадаадад ажиллах хүч гаргах үйл ажиллагааг өргөн хүрээтэй зохион байгуулжээ. Энэ үйл ажиллагааг Ким Жон Ын-ы алтны авдар гэдгээр танигдсан СХН-ын 39-р газрын харьяа гадаад хэргийн 17 хэлтэс, 100-аад худалдааны компаниудаар дамжуулан явуулсан гэж үздэг ажээ. БНСУ-ын судлаачдын тогтоосноор, гадаадад ажиллах хүч гаргахыг хариуцдаг УС-ын гол байгууллагууд нь: Худалдаа ба Гадаад Барилга Эрхлэх Газар, Шугам Сүлжээ Барилгын Ерөнхий Газар, НТХ-ны 8-р газар, 1-р тасаг, Нийгмийг Аюулаас Хамгаалах 7, 8-р Ерөнхий Газар-ууд байдаг. Түүнчлэн УС-ын дүрвэгчид ба гадаадад ажиллаж буй ажилчдыг дэмжих “УС-ын хүний эрхийг сэргээх газар” зэрэг байгууллага, дүрвэгчдийн сүүлийн үеийн ярианаас сүүлийн үед Кувейт, АНЭУ зэрэг улсад барилгын ажилчдыг явуулдаг гол байгууллага нь БНАСАУ-ын Намын 39-р газрын харьяа Гадаад Барилгын Төв Газар гэсэн мэдээ байгаа ажээ.¹⁶⁸ Дээрх байгууллагууд нь ажилчдын өмнөөс ажилчин авч ажиллуулах тухайн улсын компани, байгууллагуудтай гэрээ байгуулах, гадаадад ажиллаж байгаа ажилчдынхаа эрх ашгийг хамгаалах гэсэн үүргийн дор гадаадад ажиллаж байгаа УС-ын ажилчдын цалин хөлсийн ихэнхийг хураан авч СХН-ын 39-р газар төвлөрүүлдэг гэж үздэг байна.¹⁶⁹ Ингэснээр гадаадад ажиллах хүч гаргах нь УС-ын эрх баригчдын валют олох стандарт бус арга хэрэгслийн нэг болжээ. БНСУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дурьдсанаар УС гадаадад ажиллах хүч гаргаж 150-230 сая доллар, зэвсгийн наймаагаар 100 сая, алтны экспорт 70-80 сая / жилд 5-6 тн үйлдвэрлэдэг/, хуурамч мөнгөн тэмдэгт 2 сая, хар тамхины наймаагаар 100-200 сая ам. доллар олдог гэсэн мэдээлэл байгаа ажээ.¹⁷⁰

Ийнхүү БНАСАУ гадаадад ажиллах хүч гаргах болсон шалтгаан нь дээр дурьдсанчлан УС-ын эдийн засгийн хямрал, тухайлбал, өлсгөлөн, олон арван үйлдвэрийн газрууд сул зогссоноос үүдсэн ажилгүйдэл юм. Харин 2002 оны эдийн засгийн “шинэчлэл”-ийн бодлогын үр дүнд УС-ын хаагдмал эдийн засаг үл ялиг чөлөөлөгдсөн нь УС-ын иргэдийн гадаадад ажиллах нөхцлийг бүрдүүлж өгсөн гэж үзэж болохоор бол нөгөө талаар энэ нь УС-ын эрх баригчдын гадаад валют олох арга хэрэгсэл болсныг ч бас дурдах нь зүйтэй юм. БНАСАУ-ын гадаад худалдааны өнөөгийн байдлыг дараах хүснэгтэд харуулав.

¹⁶⁸ (북한의 해외인력송출 실태 /북한전략센터 - 코리아정책연구원 연구보고서/ 2012. 12. P.17. 『조선일보』, 2012년 4월 27일. 송봉선, “외화벌이로 연명하는 김정은,” 『월간 북한』, 2012년 8월호 (서울: 월간북한, 2012).)

¹⁶⁹ /А.Ланьков. Северная Корея после 2002 г. Попытка контр-реформ. Восток (Oriens). 2010, № 3./

¹⁷⁰ 북한의 해외인력송출 실태 /북한전략센터 - 코리아정책연구원 연구보고서/ 2012. 12. P.17. 『조선일보』, 2012년 4월 27일.)

Хүснэгт 1.

БНАСАУ-ын гадаад худалдааны нийт эргэлт (улсаар)

нэгж: 100 мянган ам.доллар, %

Улс	2007	2008	2009	2000	2011	2013	2014	2015	2016
АНУ	20,0	52 0,9	10,0	2 0,0	9 0,1	6	-	-	-
БНХАУ	1 974 41,7	2 787 49,5	2 681 52,6	3 466 56,9	5 629 70,1	6 546 89,3	6,864 90,2	5,710 91,3	6,056 92,5
Өмнөд Солонгос	1 798 37,9	1 820 32,3	1 679 33,0	1 912 3 1,4	1 714 2 1,3	-	-	-	-
Япон	9 0,2	0,1	3 0,1	-	-	-	-	-	-
Гонконг	18 0,4	40 0,7	56 1,1	31 0,5	0,2	60,8 0,83	-	-	-
Герман	51 1,1	52 0,9	7 0 1,4	59 1,0	58 0,7	25,9 0,35	-	-	-
ОХУ	160 3,4	1 11 2,0	62 1,2	111 1,8	113 1,4	104 1,4	-	-	76 1,14
Энэтхэг	126 2,7	120 2,1	60 1,2	58 1,0	51 0,6	57 1,3	-	-	58 0,9
Тайван	25 0,5	29 0,5	20 0,4	21 0,4	39 0,5	40 0,55	-	-	12 0,19
Бүгд	4 739 100,0	5 636 100,0	5 093 100,0	6 086 100,0	8 030 100,0	7 344 100,0	7 611 100,0	6 252 100,0	6 546 100,0

Эх сурвалж: 통계청 (statistics korea). 북한의 주요 통계 지표. Sonosa.or.kr

БНАСАУ-ын экспорт, импорт

нэгж: мян.ам. доллар \$

Он	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Экспорт	946.8	918.8	1130.2	1062.8	1513.6	2789.4	2880.1	3218.4	3164.7	2696.5
Импорт	2049.0	2022.3	2685.5	2351.0	2660.8	3567.7	3931.2	4126.4	4446.2	3555.3
Нийт	2995.8	2941.1	3815.7	3413.8	4174.4	6357.1	6811.3	7344.8	7610.9	6251.8
Алдагдал	-1102.2	-1103.5	-1555.3	-1288.2	-1147.1	-778.4	-1051.1	-908.0	-1281.6	-858.7

Эх сурвалж: 통계청 (statistics korea). 북한의 주요 통계 지표. Sonosa.or.kr

Түүнчлэн БНАСАУ-ын экспортын бүтээгдэхүүний ихэнх хувь буюу 40 гаруй хувийг байгалийн шатах тослох материал /нүүрс/, 20 гаруй хувийг оёдол, нэхмэлийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, 10 хувийг зэс, зэсийн хаягдал, төмөр, 8 орчим хувийг загас, далайн бүтээгдэхүүн эзэлдэг бол импортын гол бүтээгдэхүүн

нь мөн 40 гаруй хувийг байгалийн шатах тослох материал /газрын тос, чулуун нүүрс/, 20 гаруй хувийг оёдол нэхмэлийн бүтээгдэхүүн, машин үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, 20 орчим хувийг электрон бүтээгдэхүүн, эхо, дүрс оношилгооны багаж хэрэгсэл эзэлж байна.¹⁷¹ Мөн УС-ын гадаад худалдааны нийт эргэлтийн 90-ээд хувь нь ганцхан улсад буюу БНХАУ-д ноогддог ажээ.

БНАСАУ-ын хилийн чанад дахь ажиллах хүчний байдал

БНАСАУ нь төрөөс хөдөлмөрийн зах зээлийг бүрэн хянаж, төр захиргааны байгууллагаас ажлын байрны хуваарилтыг 100 хувь хийдэг. “Хөдөлмөр бол үүрэг” гэж үздэг социалист хөдөлмөрийн харилцаатай улс юм. УС-ын ҮХ-ийн 34-р зүйлд “БНАСАУ-ын ардын эдийн засаг нь төлөвлөгөөт эдийн засаг юм” гээд социалист төлөвлөгөөт эдийн засгийн бүтэц дор “ нэг нь нийтийн төлөө нийт нь нэгийн төлөө” гэсэн зарчим дээр тулгуурлана.¹⁷² БНАСАУ-ын хөдөлмөрчин бол “коммунизмын үзэл суртлыг хэрэгжүүлэхийн төлөөх хувьсгалч хүчин”¹⁷³, тэдний хөдөлмөр бол “ олон нийтийн зорилго ба эрх ашгийн төлөөх хөдөлмөрчдийн хамтын хөдөлмөр” юм гэжээ.¹⁷⁴ Солонгосын Хөдөлмөрийн хуулийн 4-р бүлэгт ажлын хэмжээ ба чанараас хамааруулж ашгийн хуваарилалт хийх нь социалист эдийн засгийн зарчим юм гэсэн¹⁷⁵ заалтууд туссан байдаг ажээ. Энэ нь тус улсын Үндсэн хууль, хөдөлмөрийн хууль, түүнтэй холбоотой хууль дүрмүүд нь жүчэйгийн онол, социализм, коммунизмын зарчимд тулгуурладагтай холбоотой юм. Тиймээс ч УС-ын хууль, дүрмүүдэд хувийн хөдөлмөр эрхлэлт, хувийн ашгийн талаар хуульчилсан зүйл үгүй ажээ. Түүнчлэн БНАСАУ-д одоогийн байдлаар гадаадад хөдөлмөр эрхлэх тухай тусгай хууль ил гаргаагүй тул тус орны энэ харилцааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхой биш байна.

БНАСАУ анх 1967 оноос ЗХУ-тай ойн салбарт хамтран ажиллах гэрээ байгуулсны дараа гадаадад ажилчид гаргах болсон түүхтэй ажээ. Гэхдээ энэ нь одоогийн гадаадад ажиллах хүч гаргах ойлголтоос огт өөр буюу хоёр орны ЗГ-ын тохиролцооны дагуу хамтын ажиллагааны хүрээнд мэргэжилтэн, ажилчин солилцох хөтөлбөр байсан юм. Харин 90-ээд оноос энэхүү солилцоо нь гадаадад ажиллах хүч гаргах бодлогын гол бааз суурь болжээ. 2000 оны дунд үеэс эхэлж УС гадаадад ажиллах хүч гаргах үйл ажиллагааг ОХУ-ын Зүүн Сибирээс авахуулаад Хятад, Зүүн Өмнөд Ази, Төв Ази буюу Ойрхи Дорнод, Африк г.м. улсад хэрэгжүүлжээ. ОХУ ба БНАСАУ-ын ЗГ-ын хооронд 2007 оны 8 сарын 31 нд хоёр талд ажиллах хүч түр солилцох гэрээ байгуулж байжээ.¹⁷⁶

А. Ажиллах хүчний тоо, хэмжээ: УС-ын хилийн чанад дахь ажилчдын талаарх судалгааг сүүлийн үед Өмнөд Солонгосын УС-ын талаарх судалгааны олон байгууллагаас судлах болжээ. УС-ын стратеги-Корегийн Улс төр судлалын

¹⁷¹ КОТРА

¹⁷² БНАСАУ-ын ҮХ 63-р зүйл, 2012, 북한 법제정보 센터

¹⁷³ БНАСАУ-ын социалист хөдөлмөрийн хуулийн 14-р зүйл, 1999, 북한 법제정보 센터

¹⁷⁴ БНАСАУ-ын социалист хөдөлмөрийн хуулийн 3-р зүйл, 1999, 북한 법제정보 센터

¹⁷⁵ Мөн тэнд 4.37

¹⁷⁶ /Бюллетень международных договоров.2010.№2 с.72-81./

хүрээлэнгийн судалгаанаас үзвэл, 2012 оны байдлаар, УС-ын ажилчид ОХУ-ын Хабаровск-д 20-25 мянга, Кувейтийн Катарын Иргэний нислэгийн газарт 3,500-4,000 хүн, Иемен-д барилга болон эмнэлгийн салбарт 150 хүн, Зүүн Өмнөд Азид 15 мянган хүн, Африкт 7-8 мянган хүн, Европт 5,000 хүн, Монголд 5,000 хүн, БНХАУ-ын Бээжин зэрэг газруудад хоолны газар, барилга дээр 7,000-8,000, сүүлийн үед Түмэн гол ба түүнтэй хил залгаа Жилин, Түмэн, Хунчүн зэрэг газарт 20,000 хүн ажиллаж байгаа бөгөөд Ляонин хойгийн Дандун-д жил бүр 20,000 ажилчдыг дадлагажигчаар авч ажиллуулахаар тохиролцоонд хүрснээр БНХАУ-д гэхэд л нийтдээ 50,000 орчим ажилчин ажиллах төлөвтэй байна. Кэсоны чөлөөт бүсийн хувьд 2006 онд 30 ААН байсан бол одоогийн байдлаар 123 ААН-д 50 мянган хүн үйлдвэрт ажиллаж, нэг жилийн орлого нь 30-40 мянган ам. доллар байна.¹⁷⁷ Мөн Өмнөд Солонгосын өдөр тутмын сонинд, өнөөгийн байдлаар дэлхийн 40-өөд улсад УС-ын 60-60,5 мянган хүн ажиллаж байгаа ба жилийн нийт орлого нь ойролцоогоор 150-250 сая ам.доллар орчим байдаг гэсэн мэдээ гарчээ.¹⁷⁸ Оросын хэвлэл мэдээлэлд, УС-ын ажилчид 2005 оны байдлаар ОХУ-ын Алс Дорнодод, тухайлбал Амур орчмын мод бэлтгэлийн ажил дээр мянга, Приморскийн хязгаар нутагт газар тариалан, загасны АА-д 3 мянга орчим ажилчин ажиллаж байна.¹⁷⁹

Харин Асан-ы улс төр судлалын хүрээлэнгээс гаргасан илтгэлээс үзвэл 2013 оны байдлаар, Алжир, Ангол, БНХАУ, Экваторын Гвиней улс, Эфиопия, Кувейт, Ливия, Малайз, Монгол, Мьянмар, Нигери, Оман, Польш, Катар, ОХУ, Арабын Эмират(UAE) гэсэн 16 улсад 52000-53000 орчим УС-ын ажилчид ажиллаж байна гэсэн судалгаа хийгджээ. Тухайлбал, ОХУ-д 20000, БНХАУ-д 19000, Монголд 1300-2000, бусад улсад 12-13 мянга орчим ажилчид байна. Энэхүү судалгаа нь 2015 оны 7 сард АНУ-ын Төрийн Департаментын судалгааны үр дүнд үндэслэгдсэн гэжээ.

Дээрхи судалгаануудаас харахад хилийн чанадад ажиллаж байгаа УС-ын ажилчдын тоо хэлбэлзэл ихтэй, бодит тоо харилцан адилгүй байгаа нь ажиглагдаж байгаа ба ерөнхийдөө 50–55 мянга орчимд хэлбэлзэж байна гэж үзэж болохоор байна.¹⁸⁰ Газар орноор нь жагсаавал ОХУ-ын Алс Дорнод буюу Хабаровск, Амур мөрний орчим, Приморскийн хязгаар, мөн нийслэл Москвад, БНХАУ-ын УС-той хил залгаа Жилин, Түмэн, Хунчүн, мөн нийслэл Бээжинд хамгийн олноороо ажиллаж байгаа ба дээр дурьдсан Ойрхи Дорнод ба Африкийн зарим улс, Өмнөд Азийн хэд хэдэн орон, Зүүн Европын Чех, Польш¹⁸¹ зэрэг улсууд ба Зүүн Хойд Азийн Монгол зэрэг орнуудад ажиллаж байгаагаас нь харахад өмнө нь сайн харилцаатай байсан улс орнууд ба хөгжиж байгаа орнуудад ихэвчлэн ажиллаж байгаа дүр зураг харагдаж байна.

Б. Ажиллах салбар ба ажлын хөлс: УС-ын ажилчид ОХУ-д мод бэлтгэл, газар тариалан/эрдэнэ шишийн тариалалт/, загас агнуурын салбарт, Ойрхи

¹⁷⁷ (북한전략센터-코리아경책연구원 연구보고서 북한의 해외인력송출 실태 2012. 12. P.18)

¹⁷⁸ 『조선일보』, 2012년 6월 22일.

¹⁷⁹ Россия - Корея: взгляд из прошлого в настоящее. А. Торкунов, В. Денисов. Мировая экономика и международные отношения. - 2005. - № 1

¹⁸⁰ Өнөөгийн байдлаар Чех, Польшийн визинд хориг тавьснаар УС-ын ажилчид ихэнх нь гарчээ.

¹⁸¹ Мөн тэнд

Дорнодод барилга, газрын тосны үйлдвэрлэл, зам, суваг зэрэг барилгын салбарт, Африкт ерөнхийлөгчийн ордон, төрөл бүрийн хөшөө дурсгал, том хэмжээний хэв цутгамал, цэргийн тоног төхөөрөмжийн байгууламж, газар тариалан болон эмнэлгийн салбарт ажиллаж байна. Зүүн Европт хөнгөн үйлдвэрлэлийн салбарт ихэвчлэн эмэгтэйчүүд ажиллаж байгаа бол Зүүн Өмнөд Азид гол төлөв барилгын салбарт ажиллаж байна. Хятадад мод боловсруулах үйлдвэр, хүнд аж үйлдвэрийн салбарт ажиллаж байгаа бол Монголд барилга, газар тариалан, хөнгөн үйлдвэрийн салбарт ажиллаж байна. Ойрхи Дорнод Ливи, Кувейт, Арабын Эмират зэрэг улсуудад ихэвчлэн барилга дээр ажилладаг бол сүүлийн үед Африкийн улсуудад Мансудэ-гийн уран бүтээлийн үйлдвэрийн газраас хөшөө дурсгал барих, замын барилга зэрэг ажил хийдэг ба зарим нэг Ойрхи Дорнодын оронд ч энэ төрлийн үйл ажиллагаа өргөжиж байна. Зарим нэгэн мэдээллийн эх сурвалжаас Мьянмарын ЗГ-тай нууцаар хонгилын барилга байгууламж, цөмийн тоног төхөөрөмжийн бүтээн байгуулалт, Сирид цөмийн эрчим хүчний станцын бүтээн байгуулалт зэрэг нууц ажил ч хийж байна гэсэн мэдээ байдаг ч энэ нь бүрэн батлагдаагүй болно.

Түүнчлэн УС-ын гадаадад ажил эрхэлдэг нийтлэг, онцлог салбарууд байдаг. Үүнд:

- Ресторан, хоолны газар. Энэ нь Хятадад хамгийн их ба ОХУ-ын Москва, Камбож, Индонези, Тайланд, Лаос, Монгол зэрэг улсуудад өргөжих хандлагатай байгаа аж. Үүнийг Пхеньяны олон нийтийн байгууллага болох гадаад үйл ажиллагааны тусламжийн удирдах газар, гадаад даатгалын ерөнхий газар, залуучуудын эвлэл, худалдааны байгууллагууд, соёлын байгууллагууд, Коре зочид буудал, Янганду зочид буудал энэ салбарт идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна.
- Эмчилгээний салбар. ОХУ, Ойрхи Дорнод, Африк, Монгол зэрэг оронд ардын уламжлалт эмчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг юм. Энэ салбарын хувьд ажиллаж байгаа хүмүүсийн тоо нь бага ч ашиг өндөртэй ажлын байранд тооцогдоно. Пхеньяны улаан загалмайн Эмнэлэг, Пхеньяны Анагаах Ухааны Сургуулийн Эмнэлэг зэрэг газраас эмч нарыг явуулдаг байна.
- Таэквондогийн багш хийхээр гадаадад ажиллах тохиолдол цөөнгүй ба ихэвчлэн Африкт үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Чосоны тэквондогийн холбоо хариуцаж явуулдаг байна.
- Цэргээс явуулах тохиолдол байдаг ч энэ нь байнгын биш ажээ. Үүний жишээ нь Вьетнамын дайн, Ойрхи Дорнодын дайн ба 1980-аад онд Угандагаас эхлүүлээд Африкийн иргэний дайнд цэрэг илгээж байжээ. Солонгосын Ардын Армийн Зэвсэгт Хүчний Газраас ихэвчлэн явуулж байжээ.
- Үүнээс гадна тамирчид гаргах тохиолдол ч байдаг ба үүнийг УС-ын олимпын хороо, улсын биеийн тамирын хороо, мөн Пхеньяны биеийн тамирын хорооноос явуулж байна.

УС-ын хилийн чанадад ажилладаг ажилчдын дундаж цалин 300-500 ам.доллар бөгөөд үүний ихэнх нь ажилчны өөрийнх нь орлого бус улсын орлого ба ажилчдад

цалингийнх нь 10 хувиас бага хувь үлддэг гэж тооцоолжээ. Ажилчдын дунд хийсэн судалгаанаас: тухайлбал, 3500 ажилчин явуулсан Кувейтэд, нэг хүний жилийн цалин нь 5,000 орчим ам.доллар бөгөөд түүний 48 хувь буюу 2,400-г нь улс авдаг ба үлдсэн 2,600 долларын 10 хувь Бангладеш-д байдаг зуучлагч компани, 25 хувийг ЭСЯ-ны хөдөлмөрийн газар, 40 хувь Кувейтэд суугаа УС-ын ААН юм уу тухайн газрын дарга удирдлагын зардалд суутгана. Эцэст нь тухайн ажилчинд жилд 1,000 доллар, сард 70-80 долларын цалин ногддог гэсэн нарийвчилсан судалгаа хийгджээ.¹⁸²

Зүүн Европ Чех-д ихэвчлэн оёдлын салбарт ажилладаг эмэгтэйчүүдийн сарын цалин 150 доллар орчим байдаг бол түүний 75-80 долларыг улсдаа буюу 39-р газар шилжүүлнэ. Байрны зардал 40 доллар орчим байдаг гэж үзвэл гар дээрээ 30 долларын цалин авдаг ажээ.¹⁸³ Үүнээс гадна гадаадад явж ажиллахын тулд эрх мэдэлтэн, албан тушаалтанд тодорхой хэмжээний мөнгө буюу хахууль өгөх, 30-50 ажилтны дунд байдаг нийгмийн аюулаас хамгаалахын ажилтны шимтгэл, ажилд зуучилж өгсний зуучлагчийн хөлс /10 хувь/ зэрэг шимтгэлүүд бас байдаг гэсэн мэдээ бий. Дээрх судалгаануудаас харахад УС-ын гадаадад хөдөлмөр эрхлэгчдийн дундаж цалин улс бүрээс хамаарч 300-500 ам.доллар, түүний 70-80 хувийг улсын орлого болгодог гэж үзвэл ажилчны дундаж цалин 20-30 хувь буюу 70-120 ам.доллар байна гэж үзэж болохоор ажээ. Хятад дахь УС-ын ажилчдын цалин 150 доллар байдаг нь Кэсоны ажилчдын 110 доллараас их байгаа ажээ.

Сүүлийн үед хилийн чанадад ажиллаж байгаа УС-ын ажилчдын эрх зүйн байдалтай холбоотой тэдний цалин хөлс, ажлын нөхцөл, ажлын цаг олон улсын хууль дүрэмд нийцэхгүй байна гэсэн шүүмжлэлийг Олон улсын хамтын байгууллага, НҮБ-ын Хүний эрхийн Хорооноос байнга гаргадаг байна. Учир нь Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын гэрээнүүд нь ажилчны эрхийн талаар олон улсын голлох стандартыг биелүүлэхийг шаарддаг ч БНАСАУ-ын хувьд ОУХБ (ILO)-ын гишүүн бус учир хөдөлмөрийн эрх хамгаалагдсан байдал нь учир дутагдалтай гэж үзэж ирсэн. УС хэдийгээр ОУХБ-ын гишүүн бус ч хүний эрхийн олон улсын 4 гол гэрээ болох иргэний, төрийн эрхийн талаарх олон улсын гэрээ (ICCPR), эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн талаарх олон улсын гэрээ (ICESR), бүх төрлийн эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхахын эсрэг гэрээ (CEDAW), хүүхдийн эрхийн тухай гэрээ (CRC)-нд оролцсон орны хувьд үүнтэй холбоотой хөдөлмөрийн эрхийг хамгаалан сахих үүрэгтэй аж. 2003 оны 7 дугаар сарын 1-нд баталсан гадаадын хөдөлмөрчдийн эрхийн тухай гэрээ нь 7 гол улсын хүний эрхийн тухай гэрээ юм. Түүний 2-р зүйлийн 1-д, гадаад ажилчдын талаар “өөрийн харьяаллын бус оронд хөлслөгдөхөөр болох юм уу хөлслөгдөж байгаа, хөлслөгдсөн” тухай заалтанд бүх төрлийн гадаадын ажилчин, түүний гэр бүлийн оршин суух байр сууринаас үл хамаарч оршин байгаа улсад хүний үндсэн эрхийг дээдлүүлэх эрхтэй гэж заагджээ.¹⁸⁴

¹⁸² (북한전략센터 - 코리아정책연구원 연구보고서 북한의 해외인력송출 실태. 2012. 12. p.28)

¹⁸³ (북한전략센터 - 코리아정책연구원 연구보고서 북한의 해외인력송출 실태. 2012. 12. p.44)

¹⁸⁴ (임예준, 북한 해외 노동자의 실태와 인권문제, 평화재단 평화연구원 제 73 차 전문가포럼, 2016.p. 18,19)

2003 онд Олон улсын хамтын байгууллагаас УС-ын хүний эрхийн байдлын талаарх тогтоол гаргаснаас авахуулаад тус улсыг олон улсад зөвшөөрөгдсөн хөдөлмөрийн стандартыг мөрдөхийг байнга шаардаж ирсэн. 2004 онд НҮБ-ын хүний эрхийн хорооноос гаргасан тогтоолд олон улсын хөдөлмөрийн стандартыг мөрдөх, түүнчлэн ИЛО-д нэгдэн орохыг шаарджээ. 2007 онд НҮБ-ын ЕА-аас гаргасан тогтоолд эдийн засаг, нийгэм, соёлын эрх зүйн дүрэмд тулгуурлан хөдөлмөрийн хуулийн 3-р бүлгийг зөрчсөнтэй холбогдуулан УС-ын үүргийг сануулж, санаа зовж байгаагаа илэрхийлжээ. 2008 онд НҮБ-ын ЕА УС-т хүний эрх ба хүний эрхийн үндсэн эрх чөлөөг дээдлэхийг хатуу шаардаж, хөдөлмөрийн эрхийг дээшлүүлэхийн тулд ОУХБ-тай хамтран ажиллахыг шаарджээ. 2015 онд НҮБ-ын ЕА энэ бүх хугацаанд ОУХБ-тай хамтран ажиллах шаардлага тавьж тогтоол гаргаж байсны үндсэн дээр УС-ыг ОУХБ-д нэгдэхийг шууд шаарджээ.

Монголд ажиллаж буй Умард Солонгосын ажилчдын ерөнхий судалгаа

Монгол улс Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1919 онд батлагдсан дүрмийг хүлээн зөвшөөрч, 1968 онд тус байгууллагын гишүүнээр элссэн байна. Монгол улс 2001 оны 4 дүгээр сарын 12 нд “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийг баталснаар гадаадаас ажиллах хүч авч ажиллуулах хууль эрх зүйн үндэслэл монголд бодитоор бүрэн хангагджээ. Тус хуулинд, Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүчийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд Засгийн газрын шийдвэрийг үндэслэн гадаадаас ажиллах хүч авч болно.¹⁸⁵ Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ гэж заажээ.¹⁸⁶ Гадаадаас ажиллах хүч авах харилцааг Монгол улсын Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулахаар уг хуулинд тусгажээ.¹⁸⁷ Мөн уг хуулийн 7-р зүйлд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээнд тусгах ерөнхий нөхцөлүүдийг зааж өгчээ. Гэрээний нөхцөлд: гадаадын иргэний ажиллах байгууллага, гүйцэтгэх үүрэг, гадаадын иргэний эрүүл мэндэд тавих шаардлага; цалин хөлсний хэмжээ; хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цагийн горим; орон сууц, ахуйн хангамжийн асуудал; нийгмийн даатгалын асуудал зэргээс гадна гадаадын иргэн байгалийн гамшиг, түймэр, усны үерт өртөж амь насаа алдсан тохиолдолд Засгийн газраас Монгол Улсын иргэний нэгэн адил тусламж, дэмжлэг үзүүлнэ хэмээн тусгахаар заасан байна.¹⁸⁸

¹⁸⁵ “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хууль 7.3

¹⁸⁶ Мөн тэнд 2-р бүлгийн 1-р зүйл

¹⁸⁷ Мөн тэнд 2-р бүлгийн 4-р зүйл

¹⁸⁸ Мөн тэнд 7.2.1, 7.2.3, 7.2.6, 7.2.7, 7.2.8, 7.2.9, 7.

Социализмын үед хоёр орны хооронд цөөн тооны мэргэжилтэн солилцох, 1960 онд БНАСАУ-ын тусламжаар БНМАУ-ын Төв аймгийн Алтанбулаг суманд 7 жилийн сургуулийн байр барихад 70-аад тооны ажилчид ирж ажиллаж байсан төдийгөөр хязгаарлагдаж байв. Харин 1980-аад оноос БНАСАУ-ын талаас Монголын хэд хэдэн томоохон төсөлд ажилчин гаргах асуудлыг хөндөн тавьж байжээ. Тухайлбал, 1986 онд Монголд улаан буудай тариалах, усан цахилгаан станц барих, орон сууцны барилга, металл хайлуулах завод барьж байгуулахад БНАСАУ ажлын хүчээр оролцох тухай санал солонгосын талаас тавьсан ч Монголын талаас энэ санал хэрэгжих боломж муутай гэж үзэж хүлээж аваагүй байна.¹⁸⁹ Мөн эл асуудлаар ЗХУ-ын албаны хүн БНАСАУ-аас ажиллах хүч нийлүүлэх асуудал нь хэрэг дээрээ байнга суулгах асуудал болж хувирч болох тул ажиллах хүч авлаа гэхэд тодорхой хугацаатай авахыг Монголын талд сануулж байжээ.¹⁹⁰

1990 он гарснаар гадаадад ажиллах, гадаадаас ажиллах хүч авах асуудал Монголын хувьд чөлөөтэй болсон. Монголын иргэд гадаадад ажиллах сонирхол ихэссэн, мөн Монгол улс БНСУ-тай дипломат харилцаа тогтооход БНСУ-ын ЗГ-ын албан ёсны шинжээчийн тайланд¹⁹¹ Монгол улс хэдийгээр хүн ам цөөтэй ч арьсны өнгө адил, хямд ажиллах хүчээр хангагдах боломжтой гэж дүгнэсний дагуу 1990-ээд оны дунд үеэс Монголын ажиллах хүч БНСУ-д үлэмж хэмжээгээр гарах болсон. Энэ үед Монголын эдийн засгийн хөгжил сул, Монголд томоохон төсөл хөтөлбөрүүд хараахан хэрэгжээгүй үе байсан тул гадаадын ажиллах хүчний шаардлага бараг үгүй байв. Монгол улс ба БНАСАУ эдийн засгийн харилцаа ч туйлын сул байв. 1995 онд БНАСАУ-ын Зам барилгын 90 ажилчин УБ-т Хархорин захын дээгүүр явган хүний гүүр барих ажлаар ирсэнийг эс дурьдвал энэ төрлийн харилцаа бараг үгүй байв.¹⁹² Харин 2000 оны дунд үеэс хоёр орны эдийн засгийн харилцаа нэлээд сэргэж хоёр орны Засгийн газрын болон хувийн хэвшлийн байгууллагуудын хооронд хамтын ажиллагааны эхлэл тавигдан Солонгосын 200 гаруй барилгачин манай орны бүтээн байгуулалтад оролцон, уламжлалт эмнэлэг, эмийн чиглэлээр хамтран ажиллах, өргөн хэрэглээний болон хүнсний бараа бүтээгдэхүүнийг хоёр талын зах зээлд борлуулах эхлэл тавигдаж, УС-ын ажилчдыг Монголын бүтээн байгуулалтын төсөлд оролцуулах санал санаачлагууд гарч эхэлжээ. 2005 оны 5 дугаар сард манай улсын Байгаль орчны сайд У.Барсболд БНАСАУ-д айлчилж, байгаль орчны салбарт, тухайлбал Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Ногоон хэрэм” хөтөлбөрт БНАСАУ-г оролцуулах асуудлаар санал солилцон Солонгосын мэргэжилтнүүд Монголд очиж судалгаа хийн 2006 оноос туршилтын журмаар хамтран ажиллахаар тохиролцож байв. Монголын талаас “Түмэн гол” төслийг хэрэгжүүлэх хэтийн төлөвийг харгалзан Дорнод бүсийг хөгжүүлэх төсөлд хамтран ажиллах санал тавьсны дагуу Солонгосын тал ч сонирхон судалж,

¹⁸⁹ ГХЯ-ны архив, Хн: № 172, тал 6,23

¹⁹⁰ Мөн тэнд, Хн:№ 171, тал41/

¹⁹¹ БНСУ - Монгол Улсын «гуравдахь сайн хөрш», чухаг түнш мөн . Д.Уламбаяр ,р. 69 Монгол Солонгосын харилцаа хамтын ажиллагааны тулгамдсан асуудал хэтийн төлөв(2), Монгол улс БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал .2010.11.19 «Action Report of Korean Economic Expert Delegations After the Working Visit to the Mongolia» Seoul., November 1990/

¹⁹² ГХЯ-ны архив, Хн: №193

уг асуудлыг ЭЗШУТ-ийн салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын Зөвлөлдөх комиссын ҮГ хуралдаанаар хэлэлцэж, Хэрлэн голын сав нутагт 250 га талбайд усалгаатай тариаланг хөгжүүлэх туршилтын хамтарсан аж ахуй байгуулж, үүнд УС-ын ажиллах хүчийг оруулж ирэх зэрэг яриа хэлэлцээрүүдийг явуулж байв.¹⁹³ 2007 оны 7 дугаар сард БНАСАУ-ын АДХ-ын Тэргүүлэгчдийн Дарга Ким Ён Нам-ын Монгол улсад хийсэн айлчлалын үеэр “Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын ЗГ, БНАСАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээр”-ийг 20-ны өдөр байгуулж,¹⁹⁴ улмаар 2008 оны 5 дугаар сарын 16-нд Монгол улсын Их хурлаас соёрхон баталснаар БНАСАУ-ын ажилчид Монголд ирж ажиллах эрх зүйн орчин албан ёсоор бүрджээ. Уг хэлэлцээрээр БНАСАУ-ын ажиллах хүчнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн¹⁹⁵ нь Монголын талаас Солонгосын талд үзүүлсэн нэн хөнгөлөлттэй нөхцөл байв. Ингэснээр солонгосын ажилчид “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” хуулийн 9.5-д ЗГ хоорондын гэрээнд заасан тохиолдолд ... төлбөр хамаарахгүй гэж заасны дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх ажлын байрны төлбөр /9,2 ойролцоогоор сар бүр 500 мян.төг./-өөс чөлөөлөгдсөнөөр УС-ын ажиллах хүч Монголд ажиллах боломжтой болжээ.

Мөн уг хэлэлцээрт “Хэлэлцэн тохирогч талаас хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэнд олгож байгаа ажиллах нөхцөл, цалин хөлс нь өөрийн орны ижил болон ойролцоо нөхцөлд хөдөлмөр эрхэлж байгаа иргэнд олгож байгаа нөхцөлөөс дутуугүй байна”,¹⁹⁶ “Хэлэлцэн тохирогч талууд өөрсдийн нутаг дэвсгэр дээр хөдөлмөр эрхлэх хэлэлцэн тохирогч нөгөө талын иргэнд өөрийн хууль тогтоомж, эсхүл хэлэлцэн тохирогч талуудын хооронд байгуулсан, эсхүл байгуулах хэлэлцээрт заасны дагуу эрх зүйн хамгаалалтыг эдлүүлнэ”¹⁹⁷ гэсэн чухал заалтуудыг оруулжээ. Энэ хэлэлцээрийн үндсэн дээр 2009 оны 4 дүгээр сарын 6-нд БНАСАУ-аас Монгол улсад ажиллах хүч авах асуудлаар Монгол улсын Нийгмийн Хамгаалал Хөдөлмөрийн Яам ба БНАСАУ-ын Гадаад Худалдааны Яамтай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, уг харилцааг илүү тодорхой болгосон байна. Энэ үеэс эхлэн БНАСАУ-ын ажиллах хүч Монгол улсад ирж эхэлсэн ажээ. Уг хэлэлцээрийг 5 жилийн хугацаатай байгуулсан ба 2014 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Пхеньян хотноо 3 жилийн хугацаатай сунгажээ.

¹⁹³ Монгол улс, БНАСАУ-ын харилцааны лавлах. <http://www.monembdprk.gov.mn/>

¹⁹⁴ Гадаад харилцаа. МУ-ын ГХЯ-ны мэдээллийн товхимол. 2007.8 сар. №11/187//

¹⁹⁵ “Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын ЗГ, БНАСАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээр” 4-р зүйлийн 3 заалт

¹⁹⁶ Мөн тэнд 3 зүйл 2 заалт

¹⁹⁷ Мөн тэнд 2 зүйл 2 заалт


Монгол дахь БНАСАУ-ын ажиллах хүчний тоо/ ажил мэргэжлийн ангиллаар/

д/д	Ажил мэргэжил	Нийт	Он							
			2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017
1.	Арми цэргийн албан хаагч	0	0	0	0	0	0	0	0	0
2.	Удирдах албан тушаалтан, менежер	40	0	1	1	19	19	0	0	0
3.	Мэргэжилтэн	2385	282	459	927	237	242	146	85	7
4.	Техник ажилтан, бусад холбогдох мэргэжилтэн	14057	519	1214	1501	2054	3161	2385	1910	1313
5.	Туслах ажилтан, клерк	1239	24	2011	108	1029	0	7	9	4
6.	Үйлчилгээний салбарын ажилчид,	120	0	0	0	2	104	7	5	2
7.	Үйлдвэрийн ба бусад мэргэжлийн ажилчид	262	37	45	0	32	27	58	38	25
8.	Суурь болон бусад машины оператор, угсрагч	6	0	3	3	0	0	0	0	0
9.	Энгийн ажил мэргэжил	55	0	0	0	2	2	9	36	6
10.	Багш	36	0	0	0	0	1	1	0	34
11.	Эмч	38	0	0	7	6	5	8	7	5
Нийт		18238	862	1780	2547	3381	3561	2621	2090	1396

Эх сурвалж: Хөдөлмөр Халамжийн Үйлчилгээний Ерөнхий Газар.

Дээрх хүснэгтээс, УС-ын ажилчдыг ажил мэргэжлээр нь жагсаавал: 1. Ихэнх хувь нь техникийн ажилтан буюу тусгай мэргэжлийн ажилчин, 2. Мэргэжилтэн буюу нарийн мэргэжлийн ажилтан, 3. Туслах ажилтан буюу мэргэжилгүй ажилтан, 4. Үйлдвэрийн ажилчин 5. Үйлчилгээний ажилтан, 6. Удирдах ажилтан, 7. Эмч, 8. Багш г.м. байна. Мөн эдийн засгийн ангиллаар нь авч үзвэл, УС-ын ажилчдын 70 хувь нь барилгын салбарт, 20 хувь нь боловсруулах буюу хөнгөн үйлдвэр, тухайлбал сүлжмэл, нэхмэлийн үйлдвэрт, үлдсэн 10 хувь нь ХАА, Уул Уурхай, Худалдаа үйлчилгээний салбарт ажиллагсад эзэлж байна.

Монгол дахь БНАСАУ-ын ажиллах хүчний өсөлт, бууралтын график үзүүлэлт:



Энэхүү графикаас 2012-2014 оны хооронд Монгол дахь УС-ын ажиллах хүчний тоо хэмжээ өсөлттэй байснаа 2015 оноос буурч байгаа хандлага ажиглагдаж байна.

Монгол дахь солонгосын ажилчдыг нийлүүлдэг УС-ын гол байгууллага нь БНАСАУ-ын гадаад барилгын ерөнхий газрын төлөөлөөгчийн газар, БНАСАУ-ын соёл мэдээллийн төв, сүүлийн үед БНАСАУ-ын хөрөнгө оруулалттай хоёр ч компани Монголын компани, аж ахуйн нэгж, байгууллагуудад солонгос ажилчдыг зуучилдаг болжээ. Дээр дурьдсан байгууллагууд ажилчдын өмнөөс гэрээ байгуулах эсвэл Солонгосын холбогдох байгууллагуудтай гэрээ байгуулахад нь зуучлах, мөн тус улсын хөрөнгө оруулалттай компани нь ажилчдад ажил олж өгч зуучлах үйл ажиллагааг явуулдаг ажээ. Эдгээр байгууллагууд ажилчдын өмнөөс ажил үйлчилгээний гэрээ байгуулахдаа нэг бүрчлэн бус нийтэд нь, цалин хөлсийг нь ч бас нийтэд нь тооцох явдал түгээмэл байгаа тул нэг ажилчны цалин хөлсийг тооцох аргагүй байдалтай ажээ. Мөн гэрээнд ажил олгогч тал буюу Монголын талыг байр, хоолоор хангах нөхцөл тавих нь элбэг байна. Ажилчин бүр ажил олгогчтой гэрээ байгуулаагүй нөхцөлд ажилчдын цалинг тодорхойлоход хүндрэлтэй ч УС-ын зуучлагч байгууллага нь ажлын үнэлгээг тооцохдоо Монголын зах зээлийн ажлын хөлсний үнэлгээний дунжийг тооцож хийж байгаагаас тэдний цалин хөлсийг тооцож бас болохоор ба мөн хэдийгээр УС-ын ажилчдын дунд судалгаа явуулах боломжгүй ч зарим нэгэн ажилчны ярианаас бас тодруулах боломжийг хайсан болно. Ингэсний үр дүнд Монголд ажиллаж байгаа УС-ын ажилчдын хувьд, барилгын ажилчны дундаж цалин 1-1.2 сая төгрөг буюу 400-500 \$, хөнгөн үйлдвэр буюу сүлжмэлийн үйлдвэрийн ажилчны дундаж цалин 600-800 мянган төгрөг буюу 200-300\$, үйлчилгээний ажилчдын дундаж цалин 400-600 мянган төгрөг

буюу 150-200\$ байна. Мөн солонгос ажилчдын ажлын нөхцөл, тэдний ур чадвар, бүтээмж, шаардлагыг тодорхойлох үүднээс солонгос ажилчныг авч ажиллуулж буй монголын 5 аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтнаас доорхи асуулгыг авсан болно.

Монгол дахь УС-ын ажилчдын талаарх асуулга /Монголын 5 аж ахуйн нэгж/

Аж ахуйн нэгж	Аж ахуйн нэгжийн эрхлэх салбар	Орон байрны хангалт	Орон байрны нөхцөл	Ажилчны хөдөлмөрийн чадварын үнэлэмж /сайн, дунд+ дунд-, муу/	УС-ын ажилчны давуу тал	Шаардлага /Их, дунд, бага/
№1	Барилга	Аж ахуйн нэгжээс	Нийтийн байр	Дунд-	Зохион байгуулалт сайн	дунд
№2	Хөнгөн үйлдвэр	Аж ахуйн нэгжээс	Нийтийн байр	Дунд+	Зохион байгуулалт сайн	дунд
№3	ХАА	Аж ахуйн нэгжээс	Нийтийн байр	Дунд-	Зохион байгуулалт сайн	дунд
№4	Үйлчилгээ	Аж ахуйн нэгжээс	Орон сууц	Дунд+	Зохион байгуулалт сайн	дунд
№5	Эмчилгээ	Аж ахуйн нэгжээс	Орон сууц	Сайн	Зохион байгуулалт сайн	дунд

Дээрхи асуулгаас харахад Монголд ажиллаж буй УС-ын ажилчдын ихэнх хувийг эзэлдэг барилга болон ХАА салбарын ажилчдын ур чадварын үнэлгээ доогуур байгаа ба харин хөнгөн үйлдвэр, үйлчилгээ, ардын уламжлалт эмчилгээ г.м. салбарын ажилчдын үнэлгээ дундаас дээгүүр боломжийн хэмжээнд байгаа нь харагдаж байна. Харин анхаарал татах зүйл нь бүх салбарын ажилчдын сахилга, зохион байгуулалт сайтай нь батлагдаж байна. УС-ын ажилчдын хувьд тоо, хувь хэмжээний хувьд Монголд ажиллаж буй гадаад ажилчдын дунд 2-рт жагсдаг ч хэрэг зөрчил гаргах нь бага байдгийн дээр визний хугацаа хэтрүүлэх, харлах гэсэн ойлголт бараг үгүй ажээ.

ДҮГНЭЛТ

Юуны өмнө дүгнэж хэлэхэд УС-ын ажилчид гадаадад ажиллах болсон шалтгаан нь тус улсын эдийн засгийн хүндрэлтэй шууд холбоотой ба харин энэ үйл ажиллагаа хувь хүний ашиг орлого гэхээсээ улсын валют олох арга хэрэгслийн нэг болжээ. Гэхдээ нөгөө талаас энэ нь дан ганц улсын бизнес гэж үзэх нь учир дутагдалтай. Учир нь гадаадад ажиллагсдын цалин хөлсний бага хэмжээ ажилчны гар дээр ноогддог ч энэ нь тэдний амьдрал ахуйд ихээхэн тустай төдийгүй амьдралын баталгаа болдог, бас гадаад орны хөгжил, дэвшлийг биеэр харж мэдрэх боломж олгодог зэрэг давуу талтай ажээ.

Монголын хувьд УС-ын ажилчид 2000 оны сүүлээс эхлэн орж ирсэн ба 2007 онд байгуулсан хоёр улсын ЗГ хоорондын хэлэлцээрээр БНАСАУ-ын ажиллах хүчнийг ажлын байрны төлбөрөөс чөлөөлсөн явдал нь тус орны ажилчдыг Монголд ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлжээ. Уг хэлэлцээрийг байгуулахдаа хоёр орны харилцааг бэхжүүлэх, хоёр орны хэрэгцээ шаардлагад нийцүүлэх зарчмыг удирдлага болгосон ч Монгол улс хүмүүнлэгийн зарчмын үүднээс БНАСАУ-ын эдийн засгийн хүндрэлийг даван туулахад туслах, ЗХА-ийн бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд хийгдэж буй Монголын хувь нэмэр гэж дүгнэх бүрэн боломжтой.

Монгол дахь УС-ын ажилчдын хувьд 2013, 2014 оны үед өсөх хандлагатай байж байгаад 2015 оноос буурч байгаа нь Монголын эдийн засгийн өсөлттэй нэлээд хамааралтай байгаа ба харин сүүлийн үед эрс буурч байгаа нь УС-ын цөмийн туршилт ба удаа дараагийн баллистик пуужингийн туршилтын улмаас НҮБ-ын АЗ-өөс тус улсад тогтоосон хориг арга хэмжээтэй холбогдуулан дэлхийн олон улс УС-ын ажилчдыг нутгаасаа гаргах, квотыг нь нэмэгдүүлэхгүй байх арга хэмжээнүүдтэй холбоотой байна.

УС-ын ажилчид Монголд хэрэгтэй юу гэдэг асуултанд, УС-ын ажилчдын ур чадвар сулавтар ч зохион байгуулалттай, гэмт хэрэгт холбогдох нь бага, мөн хамгийн гол нь ажлын байрны төлбөрөөс чөлөөлөгдсөн зэрэг нь бусад гадаадын ажиллах хүчтэй өрсөлдөх хэмжээнд байж болох юм гэсэн харулт дээрхи судалгаанаас урган гарна.

Эндээс үндэслэн Монгол улсын цаашид баримтлах бодлого нь хоёр орны харилцааг сайн түвшинд хадгалах, Монгол улсын цаашдын эдийн засгийн өсөлт-шаардлага, Монгол дахь гадаад ажилчдын тоо хэмжээнд нэг улсын давамгайллыг саармагжуулах, цаашдын бүс нутгийн хамтын ажиллагааны зорилгын үүднээс УС-ын сайн мэргэшсэн ажиллах хүчнийг Монголын бүтээн байгуулалтанд ажиллуулах боломжтой гэж судлаач миний бие үзэж байна.

НОМ ЗҮЙ

1. Л.В. Захарова. Экономические отношения России и КНДР в XXI в. // Азия и Африка сегодня. 2015
2. Gross Domestic Product of North Korea in 2007. Seoul, Bank of Korea. 18 June 2008.
3. “연합뉴스”, 제 1264 호. 2001.5.24
4. А.Ланьков. Северная Корея после 2002 г. Попытка контр-реформ. Восток (Oriens). 2010, № 3./
5. 박형중, 『북한의 경제관리체계: 기구와 운영, 개혁과 변화』 (서울: 하남, 2002),
6. Stephen Huggard and Marcus Noland. Famine in North Korea: Markets, Aid and Reform. New York, Columbia University Press. 2007. p. 27./
7. /KOTRA 해외무역관 보고/
8. (북한전략센터 - 코리아정책연구원 연구보고서 북한의 해외인력송출 실태. 2012.12. P.17. 『조선일보』, 2012년 4월 27일. 송봉선, “외화벌이로 연명하는 김정은,” 『월간 북한』, 2012년 8월호 (서울: 월간북한, 2012).)
9. БНАСАУ-ын ҮХ 63-р зүйл, 2012, 북한 법제정보 센터
10. БНАСАУ-ын социалист хөдөлмөрийн хуулийн 14-р зүйл, 1999, 북한 법제정보 센터
11. (북한전략센터 - 코리아정책연구원 연구보고서 북한의 해외인력송출 실태. 2012. 12. P.18)
12. 『조선일보』, 2012년 6월 22일.
13. Россия - Корея: взгляд из прошлого в настоящее. А. Торкунов, В. Денисов. Мировая экономика и международные отношения. - 2005. - № 1 /
14. (Emma Charlett-Avery et al, “North Korea: U.S. Relations, Nuclear Diplomacy, and Internal Situation”, CRS Report(July 2015),pp.23-24. НҮБ-ын УС-ын хүний эрхийн тухай тусгай илтгэл, мөн 2015 оны 9 сарын НҮБ-ын ЕА-аас гаргасан илтгэлд тулгуурлажээ. Situation of human rights in the DPRK, Note by the Secretary-General, UN Doc. A/70/362(8 September 2015),para 26.
15. 임예준. 북한 해외 노동자의 실태와 인권문제. 평화재단 평화연구원 제 73 차 전문가포럼. 2016.p. 18,19)
16. “Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай” Монгол улсын хууль
17. БНСУ-Монгол Улсын «гуравдахь сайн хөрш», чухаг түнш мөн. Д.Уламбаяр, р. 69 Монгол Солонгосын харилцаа хамтын ажиллагааны тулгамдсан асуудал хэтийн төлөв (2), Монгол улс БНСУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосны 20 жилийн ойд зориулсан олон улсын эрдэм шинжилгээний бага хурал .2010.11.19 «Action Report of Korean Economic Expert Delegations After the Working Visit to the Mongolia» Seoul., November 1990/
18. Монгол, БНАСАУ-ын харилцааны лавлах. <http://www.monembdprk.gov.mn/>
19. /Гадаад харилцаа. МУ-ын ГХЯ-ны мэдээллийн товхимол. 2007.8 сар. №11/187//
20. “Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын ЗГ, БНАСАУ-ын ЗГ хоорондын хэлэлцээр” 4-р зүйлийн 3 заалт